

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2019.03.24-2019.04.25/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339, 2017 оны 67 дугаар тогтоолуудын дагуу “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх” зарлан мэдээллийн дуут дохиог 2019 оны 03 сарын 21-ны өдрийн 16:00 цагт сумын хэмжээнд зохион байгуулж сирень дохиог 3 удаа дуугаргаж дадлага сургуулилт хийлээ. Зарлан мэдээллийн дуут дохиогоор аж ахуйн нэгж байгууллагын ажилчид, ЕБС-ийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, иргэдийг аюулгүйн 4 бүсэд шилжүүлэн байршуулж, үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. Үүнд 16 төрийн болон төрийн бус байгууллагын 334 албан хаагч, 510 хүүхэд, 25 иргэн нийт 869 иргэд хамрагдсан.



Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгийн бэлэн байдлын үзлэг, сургуулиалтад сумын мэргэжлийн ангийн 80 гаруй гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдсан.



Бүсчилсэн хөгжлийн бодлого”-д тусгах саналыг боловсруулах хэлэлцүүлгийг 2019 оны 3-р сарын 28-ны өдөр зохион байгуулж 50 гаруй иргэд хамрагдаж санал бодлоо хуваалцлаа.



Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэдалай агсны нэрэмжит математикийн олимпиадыг сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, нээн илрүүлэх зорилгоор сумын ИТХ, ЕБСургуультай хамтран IV-XII ангийн сурагчдын дунд зохион байгуулж аврагуудыг шалгаруулан шагнаж урамшууллаа.



2-р багийн малчин өрхүүдээр тойрох ажлыг 4-р сарын 17,18-ны өдрүүдэд 5 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулж сумын зүүн талын 29 малчин өрхөөр тойрч эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж сахар, даралт, явуулын эмийн сангаар

үйлчилсэн. Мөн “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Малын халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх”, “Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” зэрэг гарын авлагуудыг тарааж ажилласан. Мөн улаан загалмайн анхан шатны хороо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран материаллаг зүйлсийг малчин өрхүүдэд олгох ажлыг зохион байгуулсан.



Сумын Засаг даргын 2019 оны А/45 тоот захирамжаар Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, тооллогыг 2019 оны 04-р сарын 22-25-ны хооронд зохион байгуулж нийт 220 авто машин үзлэгт хамрагдсан байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 1-р улирлын мэдээг гаргаж аймгийн төрийн захиргаа, удирдлагын хэлтэс хүргүүлсэн. Үүнд: Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 34 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 87 нийт 121 өргөдөл хүлээн авсанаас 115 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 1 өргөдлийг дээд шатны байгууллагад шилжүүлж 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.

Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй "Нэг хором" аяны хүрээнд аймгийн цагдаагийн хэлтэс, сумын цагдаагийн хэсэг нартай хамтран иргэдэд зөрчлийн тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудаар сургалт зохион байгуулж 168 иргэд хамрагдлаа.



Шивээговь сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, цагдаагийн хэсэг сумын аж ахуйн нэгж байгууллагуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гурвалсан гэрээг байгууллаа.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Нөхөрсөг уулзалт-2019” урлаг, спортын арга хэмжээг 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр сумын ЕБСургууль дээр Гар бөмбөг, “Буухиа”, “Чанга шивнээ”, “Ийм авьяастай”, “Та Та тунгаа” зэрэг төрлүүдээр зохион байгуулж аймгийн ерөнхий боловсролын 5 сургуулийн нийт 120 гаруй ажилтан, албан хаагчид оролцож байгууллагын нийт дүнгээр Говьсүмбэр аймгийн I сургуулийн хамт олон тэргүүн байранд орж шилжин явах цөм, хүндэтгэлийн туг, мөнгөн шагналаар шагнагдлаа.




Аймгийн төрөлжсөн олимпиадууд багш нар суралцагчдыг олимпиадад бэлтгэх, төгсөх 5,9,12 дугаар ангиудад давтлагыг хуваарийн дагуу өгч байна.

2019 оны 03 дугаар сарын 23 нд Элсэлтийн ерөнхий шалгалтанд орох эрхээ нээлгэх монгол хэлний хичээлийн шалгалтанд 12 дугаар ангийн 18 суралцагч шалгалт өгсөн. Үүнээс 16 суралцагч тэнцэж, 2 суралцагч 4 дүгээр сарын 20 нд давтан дахин шалгалтанд орохоор болсон.


Монголын сурагчдын холбооны “Лидер сурагч” академиас зохион явуулдаг “Оюуны давалгаа” илгэлийн уралдааныг зохион байгуулж 1, 2, 3, 5 дугаар сургуулиас 24 илтгэл оролцсоноос 1, 5 дугаар сургуулиас 1, 2 дугаар байр эзэлсэн илтгэлийг улсын уралдаанд оролцуулахаар бэлтгэж байна.

2018-2019 оны хичээлийн жилийн төрөлжсөн олимпиадын II даваа аймагт зохион байгуулагдаж 13 судлагдахууны олимпиадад давхардсан тоогоор 16 багш, 120 гаруй суралцагч оролцлоо. Багш суралцагчдын медалийн тоо өмнөх жилийнхээс ахисан үзүүлэлттэй байна.



3-Р ЦЭЦЭРЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын “Цөм “ хөтөлбөрийн хүрээнд бага дунд бүлэгт “Тоглонгоо хөгжих” сургалтын технологийн хүрээнд “Тээвэр” “Таван хошуу мал” сэдвээр, ахлах бэлтгэл бүлэгт “Боржигон нутаг бидний бахархал” “Таван хошуу мал” сэдвээр төсөлт тоглоомоор үйл ажиллагаа явагдаж байна. Хүүхэд бүрийн хөгжлийг хангах хөгжмийн боловсролыг хөгжүүлэх зорилгоор бага гарын ятга 4, шигшүүр 10 хос, дуут хөгжим 5, хонх 10, цохилуурт халбага 20 ширхэгийг авч хөгжмийн энгийн зэмсэгтэй боллоо. Хөгжмийн зэмсэгээр хэмнэл тодорхойлох сургалтыг бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгүүдэд зааж эцэг эхчүүдэд үзүүлэх ажил хийлээ. Боржигон нутаг бидний бахархал сэдвийн хүрээнд боржигон байшингийн онцлогийг бага насны хүүхдэд танилцуулж байна.



Арга зүйч Ц.Туул ӨМӨЗО ны Баяннуур хотын Урдын хойд хошууны монгол үндэстний хүүхдийн цэцэрлэгт “Төсөлт тоглоомоор хүүхдийг хөгжүүлэх арга зүй” , “Арга зүйн судалгаа хийх замаар багш өөрийгөө хөгжүүлэх арга зүй” зэрэг сэдвээр сургалтыг зохион байгуулж ажилласнаар тус цэцэрлэг хамтран ажиллах санал тавьж манай цэцэрлэгт хөгжимөөр хүүхэд хөгжүүлэхэд нэмэр болгон 3 бөмбөр бэлэглэлээ.





Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Яргуйхан” хүүхдийн урлагийн наадамд 3-р цэцэрлэг хамтлаг дууны төрөлд 3-р байр, уран уншлагын төрөлд Ахлах Б бүлгийн Б.Эмүүжин 3-р байр эзэлсэн амжилттай оролцлоо.

Аймгийн хэмжээнд СӨБ-ын дунд зохион байгуулагдсан хөдөлгөөнт гимнастикийн үзүүлэх ажилд 30 хүүхдийн бүрэлдхүүнтэй оролцон “Ур чадвартай баг тамирчид” номинацид шалгарлаа.



СОЁЛЫН ТӨВ

Сумын ахмадуудын дунд "Ахмадаа сонсоё" нээлттэй ярилцлагыг зохион байгуулж сумын 30 жилийн ойтой холбогдуулан сумын түүхийн талаар халуун яриа өрнүүлж, Ахмад буурлууддаа "Угийн бичиг"-ийн сургалт, хөгжөөнт тэмцээнийг зохион байгууллаа. Мөн орон нутаг судлах танхимаар аялуулсан.




МУУГЗ Д.Санжаасүрэнгийн нэрэмжит Зүүн болон говийн бүсийн бүжгийн наадмаас "Шивээн ганхаа" хамтлаг Хүрэл медаль, багш МУСТА Л.Түмэнцэцэг "ШИЛДЭГ БАГШ"-аар шалгарлаа.

Багануур дүүрэгт зохион байгуулагдсан “Удам залгах үрс” Улсын уралдаанаас “Шивээн ганхаа- 2” хамтлаг ахлах насны төрөлд “Алтан медаль” хүртлээ.



Өрх бүр “Угийн бичиг” хөтлөх ажлын хүрээнд иргэдэд “Угийн бичиг” хөтлөх арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар иргэд маань хөтөлсөн угийн бичгээ ирж танилцуулж байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

Аймагт зохион байгуулагдсан Олон улсын сувилагч нарын баярыг угтсан ур чадварын тэмцээнд эрүүл мэндийн төвийн хамт олон амжилттай оролцож багаараа гуравдугаар байр эзэлсэн. Мөн ахлах сувилагч **Г.Гэрэлцэцэг** Аймгийн шилдэг сувилагчаар тодорсон амжилт үзүүлсэн байна.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг нэвтрүүлэх” сургалтанд Эрүүл мэндийн төвийн 3 албан хаагч хамрагдаж сумандаа мобайл технологийг нэвтрүүлж 23 680 100 төгрөгийн лабораторийн урвалж бодис, явуулын эхо аппарат,

зүрхний бичлэгийн аппарат, сахарын аппарат зэрэг тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг орон нутагтаа авчирлаа.



Эрүүл мэндийн төв Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хүрээнд “Цэвэр орчин бидний гэр” болзолт уралдааныг орон сууцны байрнуудын орцны дунд 1 сарын хугацаанд зохион байгуулж дүнг гарган шагналыг гардуулав. 1-р байранд 7-р байрны 2-р орц шалгарч 50.000 төгрөг орцны бүх иргэдэд витамин, 2-р байранд 13 байрны 1-р орц шалгарч 30.000 төгрөг айл бүрт витамин, 3-р байранд 2 байр шалгарч 20.000 төгрөг витаминаар тус тус шагнагдсан байна.



НИЙГМИЙН БОДЛОГО

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу ахмад настануудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сумын Ахмадын хороотой хамтран “Авьяаслаг ахмад” арга хэмжээг 2019 оны 03 сарын 18-нд зохион байгуулж 30 гаруй ахмад настан хамрагдаж шилдгүүдээ тодрууллаа.



Аймгийн нэгдсэн эмнэлгийн доторын тасгийн эмчтэй хамтран сумын хөгжлийн бэрхшээлтэй 24 иргэнд эрүүл мэндийн сургалт зохион байгуулж сургалтанд хамрагдсан иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэт хамруулж зөвлөгөө өгч ажилласан.



Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөдрөг зөвлөл холбоо, Боржигон чуулга хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн бага наадам”-ыг 4 төрлөөр зохион байгуулж сумаас 6 ХБИ оролцсоноос гоцлол хөгжмийн төрөлд 1-р байранд А.Эрдэнэчулуун, Шүлгийн төрөлд 1-р байранд Э.Цэрэн, Гоцлол дууны төрөлд 2-р байранд Ж.Наранцацрал, тусгай байранд Ё.Үүрийнцолмон нар шалгарлаа.




НИЙГМИЙН ХАЛАМЖ

"Хүнсний эрхийн бичиг"-ээр үйлчилэх "Энх-Оюу" дэвжих ХХК-тай 2019 оны 3-р сарын 29-ний өдөр гэрээ байгуулж "Хүнсний эрхийн бичиг"-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 16 өрхөд журмын талаар сургалт зохион байгуулан, гарын авлага тарааж, хөдөлмөрийн насны иргэдтэй гэрээ байгуулан 1,2-р сарын 2240000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгосон.



Ахмад настны тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу хөнгөлөлт, тусламж шаардлагатай 5 иргэнд ХХҮГ, Очирт тулга ХХК-тай хамтран 940000 төгрөгийн тусгай хэрэгслийг олгосон.



Аймгийн ХХҮГ-аас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний "Хөдөлмөрийн өдөрлөг" арга хэмжээг 04-р сарын 03-ний өдөр суманд зохион байгуулж, төрөөс баримталж байгаа хөдөлмөр эрхлэлтийн бодлого чиглэл, 2018 онд хийсэн ажлын тайланг 2019 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг иргэдэд танилцуулж ажиллалаа. Уг өдөрлөгт 68 иргэд хамрагдлаа.



БАЙГАЛЬ ОРЧИН

Сумын төв талбай болон зам дагуу тарьсан модыг тогойлох, хашааг засварлах, хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 2019 оны 04-р сарын 10-ны өдөр зохион байгуулж 4,5 га талбайн 15 м3 хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Мөн хаялга нуурын ойр орчмын хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг усны сав газрын захиргаатай хамтран зохион байгуулж 98 м3 хог хаягдлыг түүж 21-р зөрлөгийн төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.



Сумын төв хогийн цэгийн дүүрсэн нүхийг булуулж шинээр 4 метр гүн 13м урт, 10м өргөнтэй нүхийг ухуулсан.

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Суманд хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ явуулдаг дэлгүүр, лангуунууд болон архи, тамхины тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагуудад 1-р улирлын хяналт шалгалтыг зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм устгалын ажлыг зохион байгуулж, 2-р багийн нутаг дэвсгэр олон тойрмын хэц, Бэхтийн гол, Үүдийн ам, Боон ам зэрэг 190км газраар явж 6 бог, 15 бодын сэг зэмийг 4-н цэгт халдваргүйжүүлэлт хийж булж устгасан. Мөн засмал замын 2 талаар хаясан 22ш дугуй, тос маслын сав зэрэг хог хаягдлыг түүж цэвэрлэсэн.



Төлийн мэдээ: 2019 оны 4 сарын 24 –ны өдрийн байдлаар 13832 мал төллөсөнөөс ингэ-11, гүү-148, үнээ-156, эм хонь-6727, эм ямаа-6790 төллөж мал төллөлт 64,5 хувьтай байна. Төл бойжилт-99,5%-тай. Төлийн хорогдол хурга-38, ишиг-29 бүгд-67, том малын зүй бус хорогдол-72, адуу-2, үхэр-2, хонь-23, ямаа-45 байна.

Аймгийн ХХААГ сумын иргэдэд 04 дүгээр сарын 17-ны өдөр 8 нэр төрлийн “Явуулын ахуй үйлчилгээ” болох зурагчин, гуталчин, үсчин, гоо сайхан, алт мөнгөний дархан, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар, гар утас засвар, гоо сайханы бүтээгдэхүүн болон мөнгөн эдлэлийн худалдаа зэрэг үйлчилгээг 74 иргэнд үзүүлж 1994000 төгрөгийн орлого олсон байна. Мөн энэ үеэр ХХААГ-ын мэргэжилтэн Зээлийн батлан даалтын талаар сургалт зохион байгуулж 17 иргэн хамрагдсан.



Говьсүмбэр аймгийн “Сүмбэр хишигтэн зоо” мал үржлийн нэгжтэй гэрээ байгуулан хуц, ухна ялгах, хаварын ангилалт, баталгаажуулалтын ажлыг 4 дүгээр сарын 13-20 хооронд зохион байгуулж 36 хуц, 31 ухна ялган суурьшуулж ангилалт, баталгаажуулалт, ээмэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

Сумын 2 дугаар баг 21 дүгээр зөрлөгийн баруун урд 50га газарт гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөлийн 1:1000 масштабтай байр зүйн зураг үйлдэх, боловсруулах ажлыг ОНХС-ийн 2,6 сая төгрөгийн хөрөнгөөр “Шинэ геодези” ХХК-иар гүйцэтгүүлж 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр ажлын хэсэг тус ажлыг хүлээн авлаа.

МЭДЭЭ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ

О.БОЛОРМАА